



**Bers ABS**  
loyalty

# “БЭРС ЭЙ БИ ЭС ЛОЯАЛТИ ТЗК” ХХК-ИЙН 2024 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК (Хөрөнгө итгэмжлэн удирдагч)

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот

Утас: +976-70122346

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Я.Адьяахүү /"Бэрс Эй Би Эс Лояалти ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/



## **Агуулга**

---

1. ХБҮЦ-ны мэдээлэл .....	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл .....	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл .....	5

## 1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

"Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК нь 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Бэрс Финанс ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Я.Адьяхүү, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Д.Ганхүрэл болон Н.Мэнд-Амар нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК ажиллаж байна.

"Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК нь 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр 15.0 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

### Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011856259
Регистрийн дугаар	8416052
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2023/12/22
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	777
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	150,000
ХБҮЦ-ны үлдэгдэл (сая төг.)	15,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	18.0%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног
Үндсэн төлбөр төлөх давтамж	Хагас жил тутам

Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь 2024 оны эхний хагас жилд ХБҮЦ-ны хүүгийн төлбөрт 673.15 сая төгрөгийг хуваарийн дагуу төлсөн байна. ХБҮЦ-ны үлдэгдэл хугацаанд Хүснэгт 2-т харуулсан төлбөрийг төлнө.

### Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо*	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Үлдэгдэл
1	2024/07/04	3,750,000,000.00	673,150,684.93	11,250,000,000.00
2	2024/10/04	-	510,410,958.90	11,250,000,000.00
3	2025/01/06	3,750,000,000.00	521,506,849.32	7,500,000,000.00
4	2025/04/04	-	325,479,452.05	7,500,000,000.00
5	2025/07/04	3,750,000,000.00	336,575,342.47	3,750,000,000.00
6	2025/10/06	-	173,835,616.44	3,750,000,000.00
7	2026/01/05	3,750,000,000.00	168,287,671.23	-
<b>Нийт</b>		<b>15,000,000,000.00</b>	<b>2,709,246,575.34</b>	

## 2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш тайлант хугацааны байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 24.93 хувиар буурсан бөгөөд энэ нь ХБҮЦ-ны үндсэн төлбөрийн 25 хувь буюу 3.75 тэрбум төгрөг болон хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу 2024 оны 7 дугаар сарын 04-ний өдөр төлөхтэй холбоотой юм.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын өрөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2024.01.04	2024.06.30	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	15,000,413,041.15	11,261,060,578.01	-24.93%
Зээлийн дундаж үлдэгдэл	11,905,089.72	11,171,687.08	-6.16%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	1.11%	1.40%	0.29%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	3.94%	5.40%	1.46%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	39.63%	39.92%	0.29%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	59.62%	53.04%	-6.57%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	6.72	10.55	57.06%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	38.63	36.06	-6.65%
Сарын дундаж төлбөрийн дүн	761,694.21	782,123.84	2.68%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	4,729,738.98	5,115,235.23	8.15%
Зээлийн тоо /нийт/	1260	1008	-20.00%
Зээлдэгчийн төрөл	Иргэн	Иргэн	-
Барьцаа хөрөнгийн төрөл	Автомашин	Автомашин	-
Барьцаа хөрөнгийн үнэлгээ	28,944,119,999.00	24,339,806,818.00	-15.91%
Чанаргүй зээлийн хувь	0.00%	0.13%	0.13%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс: (өсөн нэмэгдсэн дүнгээр)	-	8,696,655,577.63*	-
Зээлийн үндсэн төлбөр	-	6,382,588,379.62	-
Хүүгийн төлбөр	-	2,310,556,483.80	-
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	-	3,510,714.21	-

\*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2024 оны 6 дугаар сарын эргэн төлөлт болох 1.48 тэрбум төгрөгийг гэрээний дагуу 2024 оны 7 дугаар сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-ийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг ХБҮЦ-ны төлбөрийг төлөх хугацаатай уялдуулан арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд 2024 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 4.4 тэрбум төгрөг, хадгаламжийн хүү 13.0 хувь, харилцах дансны үлдэгдэл 32.29 сая төгрөг байна

Тайлант хугацаанд "Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК нь "Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам"-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	425	-
2	Хугацаа хэтэрсэн тул буцаан шилжүүлсэн	18	173,593,864.47
3	Багцад нэмж бүртгэсэн	121	7,714,070,596.06
	<b>Нийт</b>	<b>564</b>	<b>7,887,664,460.53</b>

### 3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Бэрс Эй Би Эс Лояалти ТЗК” ХХК-ийг “Бэрс Финанс ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 23/26а/03 тоот шийдвэрээр ТУЗ-ийн гишүүнээр Я.Адьяхүү, Д.Ганхүрэл болон Н.Мэнд-Амар нарыг тус сонгож 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар ердийн гишүүн Я.Адьяхүүг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 4 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

*Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт*

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2024.03.21	Үйл ажиллагааны зардлын төсвийг батлах тухай	Компанийн 1 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг батлав.
2	2024.03.22	Хадгаламжийн данс нээлгэх тухай	Капитрон банкинд хадгаламжийн дансыг нээлгэж ХИУ-д холбогдох эрхийг олгов.
3	2024.04.10	Санхүүгийн болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайлан баталгаажуулах тухай	2024 оны 1 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн.
4	2024.05.06	Үйл ажиллагааны зардлын төсвийг батлах тухай	Компанийн 2 дугаар улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг батлав.